

ЗҮҮН ХОЙТ АЗИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭН ДЭХ МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ

**Проф.Петер Шран.
АНУ.Иллинойсын их сургууль**

Худалдаа дэлхий нийтийн цар хүрээтэй болж буй энэ эрин үед улс хоорондын эдийн засгийн хамтын ажиллагаанд хоёр талын худалдааны гэрээ хэлэлцээрээр үндэсний эдийн засгийн төлөвлөгөөгөө уялдуулан зохицуулж, интеграцчилах хэлбэр явцгүй болжээ. Үүний оронд улс орнууд гол төлөв олон улсын худалдаанд илүү зохимжтой бүтэц бий болгох, харьцангуй давуу талаа ашиглахын төлөө хамтран ажиллаж байна.Худалдаа эрхлэх, ингэхдээ хувиараа ажиллахад ийм бололцоог ашигладаг болж байна. Гадаад нөхцөл байдлын улмаас, зах зээлийн харилцааны үр нөлөө хязгаарлагдмал байлаа ч ийм бололцоог бүрдүүлж, сайжруулах нь засгийн газрын үүрэг хэвээрээ байгаа юм.Худалдааны болон нийгмийн харилцааны үнэ цэн, ашиг тус өөр хоорондоо ялгаа зөрөөтэй байгаа нь дэд бүтцийн хөгжлийн янз бүрийн салбарт нөлөөлж байна.Чухамхүү ийм нөхцөлд тээвэр, харилцаа холбоо, байгаль орчны бохирдолтод тавих хяналт зэрэг салбар дахь засгийн газар хоорондын хамтын ажиллагаа, технологийн солилцоо ерөнхийдөө зонхилж байна.

Энд миний бие олон улсын худалдаа, засгийн газрын хэмжээний хамтын ажиллагааны үндэс тулгуур нь юу байж болохыг Монгол улсын өвөрмөц онцлогтой холбон авч үзэхийг зорьсон болно.Ингэхдээ би эдүгээг хүртэл Хятад, Оросын нөхцөл байдлыг л илүү сайн мэдэх “гадны хүний” хувиар асуудалд хандаж байгаагаа та бүхэнд эрх биш сануулах нь зүйтэй болов уу. Энэ бага хуралд оролцуулахаар намайг урьсан нь Монгол орны тухай, тус улсын хөгжил дэвшил, бас Зүүн хойт Ази болон нийт дэлхий дахинтай Монгол улс ямар харилцаатай байдаг талаар сонсч мэдэхэд завшаан болсон юм.

Би энэ илтгэлдээ худалдаа, засгийн газар хоорондын хамтын ажиллагаатай холбогдсон хэд хэдэн томхон төсөл, бололцоонд анхаарлаа хандуулсан юм. Жижиг сажиг зарим нэг зүйлийг орхисон нь тэр бүгдийг онцын чухал биш хэмээн үзэж омитгойрсон хэрэг биш юм шүү. Харин ч өдий төдий жижиг аж ахуй нь Монгол улс цаашид хөгжин дэвшиж, дэлхий дахинтай ойртон жигдрэх үйл хэрэгт бүр ч үр нөлөөтэй байж болох юм.

Монгол улсын давуу, давуу бус талууд

Монгол улсын эдийн засгийн байдал, дэлхий дахинд хандсан байр суурийг ердөө хэдхэн мөрөөр нэгтгэн дүгнэж болох юм. Монгол улс нутаг дэвсгэрийн хувьд томоохон улсуудын нэг боловч хүн амынхаа тоогоор жижигэвтэр улсуудын тоонд ордог. Тус улсын хүн амын нягтрал үнэхээр бага учраас газар нутгийн нь онцлог нь суурин фермийн аж ахуйг бодвол нүүдлийн мал аж ахуйд илүү тохиромжтой юм байна. Бусад зүйл, түүний дотор дэлхий дахинтай худалдаа хийх асуудал эдийн засгийн ийм орчинд харьцангуй бага хамааралтай.

Энэ байдал нь (тухайлбал, суурин газрын ахуй амьдралын хөгжил, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл) Монгол улсыг гадаад худалдааны хувьд бусдад ихээхэн хараат байдалтай болгож байгаа юм. Дотоодын зах зээл нь уул уурхайн болон боловсруулах үйлдвэрийн хямд төсөр зардалтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөхүүлэн дэмжихэд тийм ч таатай биш байна. Түүнээс гадна, цаг агаарын байдлын улмаас суурин фермийн аж ахуй, тухайлбал газар тариалан, мал аж ахуйн хөгжил хязгаарлагдмал, татаасгүй хөгжиж чадахааргүй юм. Ийнхүү монголын хотжилт, аж үйлдвэржилтийн үйл явц нь аж үйлдвэрийн шинэ бүтээгдэхүүн, хот суурин газрын хэрэглээний бараа, ерөөс өргөн хэрэглээний бараа таваарын эрэлт хэрэгцээ, нийлүүлэлтийн хувьд гадаадаас онцгой хамааралтай байгаа юм.

Хөгжил дэвшлийн энэ чиг хандлагад гол түшиг болж байсан ЗХУ болон ЭЗХТЗ-ийн гишүүн бусад улс Монголоосол авахыгаа ч авч, өгөхийгөө ч өгдөг байжээ. Зөвлөлтийн тогтолцоо задран унасан нь худалдааны харилцаанд таагүй нөлөө үзүүлж, Монгол улс бүтээгдэхүүнээ гадаадад гаргах, бас гадаадаас бүтээгдэхүүн авах шинэ зах зээл хайж олохоос өөр аргагүй байдалд хүрсэн юм.

Түүнээс хойш эрчимтэй бус мал аж ахуй хөдөөгийн ядмаг эдийн засгийн гол тулгуур хэвээр байсан төдийгүй төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үед дахиад л зонхилогч хүчин зүйл болсон билээ. Тэрчилэн мал аж ахуй нь экспортын чиглэлээр дагнасан, бодит нөөц бололцоо, давуу талаа тодорхой харуулсан салбарын нэг юм. Ноос, ноолуур гэх мэт мал аж ахуйн бүтээгдэхүүн олон улсын зах зээл дээр хэдийнээ байр сууриа эзэлжээ. Арьс шир, нэхий зэрэг бусад бүтээгдэхүүн, мах, сүү, цагаан идээ өрсөлдөх чадварын хувьд илүү байж болох юм. Дээр дурдсан анхдагч бүтээгдэхүүнхий үнийг өсгөө гэвэл орчин үеийн боловсруулагч тоног төхөөрөмжийг эзэмших хэрэгтэй.

Үүнтэй харьцуулахад эрчимтэй мал аж ахуй, газар тариалан нь харьцангуй үржил шимтэйд тооцогдох тун бага хэмжээний газраар хязгаарлагдаж байна. Тус хоёр салбар 1980-аад оны үед эрчимжсэн нь хот суурин газрын хүнсний хэрэгцээг хангах чухал аж ахуйнх нь хувьд

фермийн аж ахуй ихээхэн суларсан юм. Гэвч уг мөн чанараараа бол тийм ч сайн биш, тогтвор муутай хэдий ч зохих хэмжээний техникийн өөрчлөлт, удирдлага зохион байгуулалтын шинэчлэлтийн хүчээр сэргээж болох тийм аж ахуйг эрхлэх боломж үлдсэн юм.

Монгол улс хадлан, бэлчээр сайтайгаас гадна ой модоор баялаг. Ийм болохоор ойн аж ахуй эрхлэх боломжтой. Ой аж ахуйн бүтээгдэхүүнийхээ дийлэнхи хэсгийг одоо ч хүртэл экспортод гаргаж байна. Мод боловсруулах салбарыг мөн л ялгаагүй хөгжүүлэх шаардлагатай байгаа юм.

Монголын нутагт арвин их эрдэс баялаг, металл, ялангуяа нүүрс, зэс, хайлуур жонш бий. Байгалийн баялагийн ашиглалт мөн л гол төлөв 1980-аад онд түргэссэнээр хотжих үйл явц ч хурдасч, тэгснээр нийт хүн амын өсөлт хотод төвлөрсөн юм. Хүн амын ийм төвлөрсөн суурьшилт тухайлбал, уул уурхайн хэдхэн бүсэнд ажиглагдаж байна. Нүүрсний аж үйлдвэрийн бүтээгдэхүүний дийлэнхи нь шууд, шууд бус замаар хот суурин газрын аж үйлдвэрийн салбарт хүрч байна. Харин зэс (зэсийн баяжмалыг гаргахад эрчим хүч асар их шаардагддаг) хайлуур жонш, уул уурхайн бусад бүтээгдэхүүн, ялангуяа алт экспортын чухал бүтээгдэхүүн юм. Энэ төрлийн бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээ, чанар чансаа ч бас дээшилж байгаа бөгөөд цаашдаа болосвруулалт нь зохистой нөхцөл байдалд улам ч үр ашигтай болж болох юм.

Нэгэн үе ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудтай хийж байсан худалдаа зогсч, тэдгээр орноос техникийн сэлбэг хэрэгсэл авахад бэрхшээлтэй болсны улмаас олон уурхайн ажилд тааламжгүй нөхцөл бий болсон. Гэвч цаашдаа алс хэтийн төлөв тун нааштай байна. Технологийн өөрчлөлт хийх асуудал шийдэгдээгүй шахам, Монголын газрын доорхи баялаг нөөцийг ашиглаж дуусах хүртэл өдий байгаа бололтой. Тухайлбал, нүүрс, шатдаг хийн шинэ шинэ орд саяхан нээгдсэн нь эрчим хүчний үйлдвэрлэлд ихээхэн ирээдүй байгаа, эрэл хайгуул хийвэл их зүйл байж болохыг харуулж байна.

Далайд гарцгүй байрлал нь Монгол улсын хувьд аргагүй л бэрхшээлтэй асуудал байдаг. Орос, Хятадын завсарт байдаг тус улс дээрхи хоёр орны хязгаар нутгуудтай хил нийлж, харин эдийн засгийн хөгжлийнх нь төвүүдээс алс зайтай оршдог. Монгол улсын хүн ам тааруу, нүүдлийн эдийн засагтай учраас дотоодын зам тээвэр, харилцаа холбооны систем нь үнэхээр сул дорой байна. Ихэнхдээ сайжруулагүй замтай болохоор аливаа ачаа барааг нааш цааш тээвэрлэхэд бэрхшээлтэй, зардал ихтэй байдаг нь дотоод, гадаад худалдааны бэрхшээл түвэг учруулж байна. Оросын талаас Сибирийн гол төмөр замын нэг зангилаа Монголд орж ирж, Улаанбаатар, Чойбалсан хүрдэг юм байна. Энэ төмөр замын орон нутгийн зангилаанууд шинээр гарч ирсэн аж үйлдвэрийн салбарыг Зөвлөлтийн эдийн засагтай холбожээ. Умард зүгт өөр бусад хэд хэдэн замаар бас тээвэр хийж байна.

Улаанбаатарын төмөр зам хятадын төмөр замын сүлжээтэй холбогддог бөгөөд Сибирь дамжсан худалдааны уламжлалт замын төгсгөл Замын-Үүд хүрдэг байна. Гэвч Хятад руу очих үүнээс өөр томхон төмөр зам огт алга. Одоо Улаанбаатар төмөр зам дамжин өнгөрөх гол зам хэвээр байгаа бөгөөд ийнхүү Монгол улсын хувьд Хятадад хүрэх, мөн дэлхийд гарах гарц хязгаарлагдмал, гагцхүү Сибирийн гол төмөр замаар л дамждаг тул их тойруу байдаг. Оросын төмөр зам өргөн, Хятадынх нарийн учраас байдал бүр ч ярвигтай. Саяхан Японы тусламжтайгаар техникийн шинэчлэлт хийсэн хэдий ч ачааг шилжүүлэн ачих, галт тэрэгний дугуйг сольж тохируулах зэрэг ажиллагаа нь цаг хугацаа, зардал төсөв их шаарддаг байна.

ЭЗХТЗ тарж, Оросын эдийн засаг доройтсон тул Монгол улс худалдааны бодлого Хятад, Зүүн Азийн бусад улс, улмаар Номхон далайн зүгт хандуулсан юм. Газар нутгийн чиглэл ийнхүү өөрчлөгдсөн нь Улаанбаатар төмөр замын ашиглалтад нөлөөлж, Хятадын хувьд зохицуулах хүчин чадалтай холбогдсон хүндрэл бэрхшээл учирч байгаа нь эргэлзээгүй. Хэдий тийм боловч Хятад улс энэхүү хэрэгцээ шаардлагыг хангаж, Тяньжин боомт хүртэл дамжин өнгөрөх бололцоог Монгол улсад баталгаатай олгож байна.

ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХАМТЫН АЖИЛЛАГАА

Монгол улс уул уурхай, эрчимгүй мал аж ахуйн салбар дахь харьцангуй давуу талаа ашиглахад анхаарал хандуулахдаа эдийн засгийн хөгжлийн эрх ашгаа урьтал болгож байна. Дээрхи салбарын бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх, нэр төрлийг олшруулах, чанарыг дээшлүүлэхийн тулд Монгол улс илүү зохимжтой технологийг импортоор оруулж ирэх ёстой. Бүтээгдэхүүнээ дэлхийн зах зээл дээр гаргахын тулд хөрш зэргэлдээ улс орнуудад хүрч, дамжин өнгөрөх шаардлагатай. Энэ бүх зорилгод хүрье гэвэл дотоодынхоо зам тээвэр, харилцаа холбооны сүлжээг хөгжүүлж, гадаадтай улам эрчимтэй холбоо тогтоох нь зүйтэй.

Тус улс дэлхийн эдийн засгийн интеграцид оролцохын тулд хөрш улсуудтайгаа, дээрхи үйл явцад оролцож буй өөр бусад талтай хамтран ажиллах шаардлагатай.

Монгол улсаас гадаадын орон ч бай, пүүс компани ч бай бусадтай тогтоох хамтын ажиллагаа “хоёр урсгалтай гудамж” байх нь мэдээж. Талууд нэг төсөл дээр тохиролцож, түүнийг хэрэгжүүлэхэд нөөц бололцоогоо дайчлахаар болвол аль ч талын эрх ашгийг бодолцох нь

зүйн хэрэг. Хамтран ажиллагчид маань янз бүрийн учир шалтгааны улмаас тухайн төслийн үр дүнгээс ашиг харж байж болох юм.

Монгол улсаас бусад талтай тогтоох хамтын ажиллагаа нь харилцан ашигтай, харилцан хамааралтай төслүүдийг хэрэгжүүлэхийн тулд гаалийн татвар, виз зэргээс өгсүүлээд дотоодын уялдуулан зохицуулсан үүрэг хариуцлагын хэлбэртэй байж болох юм. Энэ хэлбэрийн хамтын ажиллагаа Монгол улсаас Хятад, Оростой тогтоосон харилцаанд, ялангуяа тээвэр, харилцаа холбооны салбарт онцлог шинжтэй болсон юм шиг байна. Үүний тодорхой жишээ нь дамжин өнгөрөх замуудыг гэрээ хэлэлцээртээ тусгаж, харилцаа холбооны бусад сүлжээг харилцан ашиглаж байгаа явдал мөн. Харамсалтай нь ийм хамтарсан төслүүдийг хэрэгжүүлэхэд их төлөв Монголын талаас шалтгаалсан бэрхшээл тулгарч байна. Учир нь шаардлагатай арга хэрэгсэл илт дутмаг байна. Монголын үндэсний нийт хадгаламж /ҮНХ/ 1993 оноос хойш дундажаар дотоодын нийт бүтээгдэхүүний /ДНБ/ 19 хувь байгаа нь Алс Дорнодын түргэн хурдацтай аж үйлдвэржиж байгаа улсуудынхаас харьцангуй бага байна.¹ Хэрэв энэ үзүүлэлтийг хоёр дахин өсгөвөл нийт хөрөнгө оруулалтын сан нь монголын хүн ам болон бүтээгдэхүүний хэмжээ нутаг дэвсгэртэй нь харьцуулахад бага байгаагаас болоод нилээд хязгаарлагдмал хэвээр байх болно. Монголын дотоодод гадаадын хөрөнгө оруулалт, техникийн тусламж байхгүй аваас эдийн засгийн хамтын ажиллагаа нэг их явахгүй.

Монголын дотоодын нийт хөрөнгө оруулалт 1993 оноос хойш ДНБ-ний дундажаар 25 байсан бол тэр үеэс хойших гадаадын хөрөнгө оруулалт дундажаар ДНБ-ний 6 хувь байна.² Монгол улсын хувьд гол хандивлагч нь Япон улс байв. Дэмжлэг үзүүлэх анхдагч эх үүсвэр болохын хувьд Япон улс Азийн хөгжлийн банк (АХБ), Дэлхийн банктэй нэгдсэн юм. Монголд албан ёсны зээл олгогч хамгийн гол түнш болох Япон 1992-1996 онд тус улсад үзүүлсэн зээлийн тусламжийн 58,4 хувийг эзэлж, зээлийн дийлэнхийг дэд бүтцийн салбарт зориулсан байна.³ 1992-1996 оны хооронд олгосон албан ёсны бүх зээлийн 23,7 хувийг эзэлж буй японы дунд, урт хугацааны зээл нь хэмжээгээрээ АХБ-наас олгосон зээлийн (33,8 хувь) дараа, **хоёрдугаарт**, харин Дэлхийн банкнаас олгосон зээлээс (19,9 хувь) илүү байна. Олон улсын валютын сангийн (ОУВС) шугамаар олгодог Бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлэх зориулалттай зээлийг эс тооцвол бусад улс орон олон улсын байгууллагуудаас олгож буй зээлийн хэмжээ тун хязгаарлагдмал байна.⁴

1991-1996 онд Монгол улс нийт 1,2 тэрбум орчим долларыг зээл, буцалтгүй тусламж, техникийн тусламжийн хэлбэрээр авсан байна. Хөгжил дэвшилд нь дэмжлэг үзүүлэх зорилготой энэ мэт тусламжийг НҮБ-ын Хөгжлийн программ, Япон улс болон Дэлхийн банкнаас санаачлан хийлгэдэг хандивлагчдын бага хурлаар жил бүр Монгол улсад үзүүлж байна. Энэ бага хурал нь Монгол улсад үзүүлэх хандив тусламжийг цуглуулж, зохицуулахын зэрэгцээ зарцуулалтынх нь байдлыг

хянаж байх зорилготой юм. Хандивлагчдын VII уулзалт 1997 оны аравдугаар сард болж, 1998 онд 256 сая долларын хандивыг Монгол улсад өгөхөөр шийдвэрлэсний 30 хувь нь буцалтгүй тусламж 70 хувь нь хөнгөлөлттэй зээлж байна.⁵ Харин Монгол улс амласан бүх зээлийн дэмжлэгийг шингээхэд бэрхшээлтэй тал ажиглагдаж байна.

Харин арилжааны ашиг Монгол улсад нэлээд их орхигджээ. Гагцхүү 1992 онд л арилжааны зээл албан ёсны зээлийн дэмжлэгт ихээхэн нэмэлт хүч болж, тэгснээрээ зэсийн уурхайг шинэчлэхэд ач тусаа үзүүлсэн байна.⁶ Өнгөрсөн хэдэн жилийн хугацаанд гадаадын арилжааны шууд хөрөнгө оруулалт тун бага хэмжээгээр боловч ахижээ. Дашрамд хэлэхэд, Зүүн хойт Ази болон бусад бүс нутгийн гадаадын пүүсүүд Монгол улсын саналыг саяхан болтол нэг их тоодоггүй байсан бололтой. Гэтэл тус улс уул уурхайтай холбогдсон хууль тогтоомждоо өөрчлөлт оруулж, улсын олонхи үйлдвэр, аж ахуйн газрыг эрчимтэй хувьчилснаар одоо гадаадынхны анхаарлыг татаж эхэлжээ.

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨСЛҮҮД

Түрүүчийн тайлбарууддаа арилжааны болон албан шугамаар хамтарсан үйлдвэр байгуулах бололцоог зарчмын хувьд дурдсан. Харьцангуй давуу тал байна гэж бодож байгаа бол бизнес хүн зохих нөөц бололцоогоо өөрийн санаачлагаар дайчлаад үзэж болох юм. Хамтын ажиллагаанд ингэж ямар нэг байдлаар оролцох нь ямар ч тохиолдолд орлого, зарлага хир тэнцвэртэй байхаас хамаарна. Энд хэд хэдэн төслийг тоймлон авч үзвэл, засгийн газар олон улсын байгууллага болон пүүс компаниуд хоорондоо олон янзын хэлбэрээр хамтран ажиллаж байгааг харж болох байна.

Нефть олборлолт: Монгол улс урьд өмнө нефтийн нөөцийг судлах, энэ салбарыг хөгжүүлэхэд муу анхаарч байсны улмаас нефтийн бүтээгдэхүүнээ одоо хүртэл импортоор авч байна. Дотооддоо нефть боловсруулах хүчин чадалгүй тул байдал мөддөө өөрчлөгдөх төлөвгүй байна. Гэвч саяхнаас засгийн газар гадаадын нефть хайгуулын пүүсүүдтэй хамтарч ажиллах болсноор түүхий нефть олборлох, экспортод гаргах хэтийн төлөв сайжирч эхэллээ. ОУВС хөгжлийн энэхүү чиг хандлагыг 1996 оноос эхэлнэ хэмээн үзэж байлаа⁷. "Алс дорнодын эдийн засгийн тойм" сэтгүүл 1998 оны нэгдүгээр сарын 29-ний дугаартаа нефть олборлолт нь "... Монголын төсөвт жил тутам 800 мянган долларын орлого оруулж байна..." гэж дурдаад,

...Монголын газрын тосны хэрэг эрхлэх газар Канадын Мэнтауэр Пэтролэум компанитай бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулжээ. Тус компани хоёр талбайд туршилтын зургаан цооног өрөмдөхөд 10 сая орчим долларын хөрөнгө оруулах юм.

Согамо (Соко Тамсаг Монгол) гэсэн нэрээр ажилладаг Америкийн Соко компани хайгуулын хоёр талбайд 30 сая гаруй долларын хөрөнгө оруулаад байна. Энэ жил Согамо үйл ажиллагаагаа хэдэн мянган ам.дөрвөлжин километр талбайгаар өргөжүүлж, дахин 21,4 сая долларын хөрөнгө оруулах юм.

Бүтээгдэхүүнээ байнга экспортлож эхлэх төлөвтэй байгаа Соко компани Монголын дорнод нутагт Тамсагаас Хятадын хил хүртэл нефть дамжуулах 100 км урт хоолой тавихаар төлөвлөж байна. Тамсаг авто болон төмөр замаас хол зайтай ч нефть боловсруулах үйлдвэрийн сэлбэг хэрэгслийг Хятадаас төмөр замаар авах бололцоотой юм гэжээ.⁸

Хятадын талаас тээвэрлэж ирэх энэхүү төмөр зам гэдэг нь Тамсагаас зүүнтээ Өвөр Монгол дахь Иршийн төмөр замын өртөөг хэлж буй бололтой. Нэг хэсэгтээ нефтийг Тамсагаас баруун урагш Сүхбаатар аймгийн нутагт шинээр нээгдсэн Бичигтийн боомтоор дамжуулан Хятад хүртэл 300 гаруй км газар автомашинаар тээвэрлэх юм.⁹

Энэ нутаг дахь тээврийн бололцоог цаашдаа АХБ-ны дэмжлэгтэйгээр тавих 1000 км урт авто замаар өргөжүүлнэ. Энэ зам Улаанбаатараас Өндөрхааныг дайран Дорнод хүрч, хойт зүгт Орос, зүүн зүгт Хятадад очих бөгөөд хятадын чиглэл нь Тамсагийн нефтийн орд¹⁰ газрыг дайран Ирши орох юм. Тамсагбулагийг Чойбалсан, Зүүн булагтай холбосон нарийн төмөр зам байсан боловч одоо үгүй болсон бололтой (?). Хятадын үндэсний нефтийн корпорацийн ашигладаг байсан энэ төмөр зам дээрхи орд газарт (бас ойр хавьд шинээр нээгдэж болзошгүй нүүрсний орд газарт) хүрэх бас нэг зам болж болох ажээ. Ингэснээр Монголын зүүн нутгаас Хятад цаашилбал Номхон далайд хүрэх хамгийн шууд дөт зам ч нээгдэж болох юм. Гагцхүү төмөр зам өргөн, нарийн гэхгүй нэгэн жигд байгаасай хэмээн найдаж байна.¹¹

Нефть хайгуул Дорнод аймгийн Тамсагт (болон Зүүнбаянд) төдийгүй зүүн өмнөд нутагт ч үргэлжилж байна. Дээр өгүүлсэн Канадын Мэнтауэр Пэтролэум компани төмөр замын дагуу оршдог Дорноговь аймагт өрөмдлөг хийж байгаа юм. Монголнефть компани Соко Интернейшнл болон Канадын Территориал Ресурсес компанитай хамтран Дорноговиос баруунтай Өмнөговь аймаг дахь Галбын XI талбайд хайгуул хийж байна.¹² Дээрхи хоёр талбайн аль алинд нь авто, төмөр зам, нефть дамжуулах хоолой тавих төлөвлөгөө яригдаж байгаа бололтой. Гэхдээ тэнд Өвөр Монголын хэд хэдэн автозам, Бугатаас умард зүгт Баян-овоогийн төмөр замын зангилаатай холбогдох бололцоотой. Ингэснээр тэндээс олдсон нефтийг бас экспортод гаргаж болох юм.

НҮҮРСНИЙ УУРХАЙ

Монгол улс нүүрсний асар их нөөц баялагтай боловч энэ салбар ихэнхдээ сул дорой хэвээрээ байна. Их төлөв умард нутаг дахь хуучин уурхайнуудыг зогсонги байдлаас нь гарахын тулд 1991 оноос хойш олон улсын тусламжтайгаар шинэчилж эхлээд байна.¹³ Энэ ажилд зориулсан хөрөнгө зардлын дийлэнхийг олон улсын банкууд болон Япон улс гаргажээ.¹⁴ Ийнхүү хүч чармайлт тавьж байгаа хэдий ч 1990-ээд онуудад нүүрс олборлолтын хэмжээ буурснаар¹⁵ Монгол улсын эрчим хүчний баланст зохисгүй нөлөөлж байна.¹⁶ Түүгээр зогсохгүй Дэлхийн банкны 1992 оны судалгаагаар, тус улсад нүүрс олборлолт түргэн хугацаанд нэмэгдэх төлөв үгүй байна. Дээрхи судалгаанд:

...Тус орны өмнө хэсэгт чулуун нүүрсний шинэ шинэ томхон ордын хайгуул хийхэд уул уурхай хөгжүүлэх хөрөнгө төсөв, нэгдмэл дэд бүтэц, түүний дотор тоног төхөөрөмж шаардагдаж байгаагаас гадна нүүрсийг Монголын хил хязгаар нутгуудад тээвэрлэн хүргэх төмөр зам тавих хэрэгтэй байна. ЗХУ, Хятадын аль алин нь Монголын нүүрсийг авах бололцоогүй байгаа болохоор уг бүтээгдэхүүнийг гадаадын өөр худалдан авагчдад хүргэе гэвэл эхлээд төмөр зам тавих, хилийн боомтын тоног төхөөрөмжтэй болохын тулд нэмэлт хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Хүхэр багатай нүүрсийг Хятад, Австралиас харьцангуй хямд үнээр авч болох учраас Монголын нүүрсийг дотоодын хэрэглээг нь эс тооцвол экспортод гаргах эдийн засгийн бодлого тодорхойгүй байна гэж дүгнэжээ.¹⁷

Хятад улс Түмэн голын төслийг дэмжиж байгаа болон ялангуяа Чойбалсанг Иршитэй холбох төмөр зам тавигдчихвал дээрхи төлөв байдал өөрчлөгдөж болох юм. Нүүрсний нөөц ашиглалтыг сайжруулах хоёр дахь хэтийн төлөв нь ЗХА-ийн эрчим хүчний сүлжээ байгуулахтай холбоотой юм. Монголын төв эрчим хүчний систем нь Оросын системтэй холбоотой, баруун таван аймгийг энэ системд бас холбох гэж байна¹⁸. Одоо Монгол улс эрчим хүч экспортлохоосоо илүү импортоор авч байгаа юм. Гэвч тус улсын нутаг дэвсгэрийг хөндлөн гулд холбосон өндөр хүчдэлийн шугам тавих санал санаачлага хэрэгжвэл зүүн болон өмнөд нутгийн төв хэсэгт цахилгаан станцад зориулсан нүүрсний уурхайг хөгжүүлэх бололцоо бүрдэх юм.

Энэхүү хэтийн төлөвөөс хамаарахгүйгээр Монголын өмнөд нутгийн төв хэсэгт гадаадын шууд хөрөнгө оруулалтаар нүүрсний уурхай ажиллаж эхлээд байна. Чехийн Эшиа инвестмент капитал групп Өмнөговийн Таван толгойн нүүрсний орд газрыг ашиглах гэрээ байгуулсан бөгөөд тэндээс коксждог нүүрс олборлох юм. Энэ төслийн дагуу 10 мянган айл өрхтэй шинэ хот байгуулж, төмөр зам тавих юм¹⁹.

Хойд нутгийн нүүрсний уурхай, цахилгаан станцуудыг гадаадын тусламжтайгаар шинэчилмэгц хувьчлахаар бэлтгэж байгаа юм²⁰.

Түүнээс гадна тэдгээрийг Оросын эрчим хүчний сүлжээтэй холбовол Монгол улс тун ойрын үед цахилгаан эрчим хүч экспортлогч болж ч болох юм. Учир нь Орос улс цахилгаан эрчим хүч худалдах төдийгүй худалдан авах ч сонирхолтой байна.

Шатдаг хий дамжуулалт: Монгол улс шатдаг хийн орд үгүй боловч Оросын Байгаль нуурын бүс нутгаас Умард Хятадын өндөрлөг хүртэлх тээврийн хамгийн хэмнэлттэй зам тус орны нутгийг дайран өнгөрдөг. Иймд Монгол улс ЗХА-ийн хий дамжуулах хоолой тавих төсөлд нэгдэж, дээр дурдсан эрчим хүчний сүлжээний бүрдэл хэсэг нь болно. Хятад, Япон хоёрын аль алин нь Сибирээс шатдаг хий авахыг сонирхож байна. “Алс дорнодын эдийн засгийн тойм” сэтгүүлийн 1997 оны аравдугаар сарын 30-ны дугаарт,

...Японы улсын мэдлийн Үндэсний нефтийн корпораци Эрхүүгээс умард зүгт орших шатдаг хийн Ковыктинскийн орд газрыг түшиглэн хайгуул хийхээр өөрийн улсын 10 шахам пүүсээс бүрдсэн судалгааны багийг саяхан байгуулжээ. Японы баг 850 тэрбум шоо метр шатдаг хийн нөөцтэй гэж үзэж буй энэ орд газраас Монголын нутгийг дайруулан Бээжин, болвол Солонгос, Япон хүртэл хий дамжуулах хоолой тавихаар төлөвлөж байна. Гэвч уг судалгааны ажил нь хараахан эхлээгүй болохоор албаны хүмүүс эргэлзээсхийж байгаа хэдий ч хий дамжуулах хоолой тавих ажил 10 жилийн хугацаанд багтаж эхэлнэ хэмээн найдаж байна гэжээ²¹.

Түүний дараахан хэдийгээр Япон улс болгоомжтойхон мэдэгдэл хийж байсан хэдий ч дээрхи төсөл хэрэгжих нэлээд ирээдүйтэй нотолгоо бүрдсэнийг дараах мэдээ харуулсан билээ.

...Арваннэгдүгээр сарын 10-нд (1997 он) Ерөнхийлөгч Б.Ельцин, Ерөнхийлөгч Зян Зэмэнь нар Сибирийн орд газраас Монголын 1000 км нутгийг дайруулан Хятадын Шандун муж хүртэл шатдаг хий дамжуулах хоолой тавих тухай өргөн хүрээтэй хэлэлцээрт гарын үсэг зурав. Цаашдаа энэ хоолойг өргөжүүлж, Япон, Өмнөд Солонгост шатдаг хий хүргэх юм²².

Түүнээс гадна бүс нутгийг хамарч байгаагийнх нь хувьд уг төсөлд Орос, Хятад, Япон, Өмнөд Солонгос, Монгол улсыг оролцуулахаар заажээ²³. Хэлэлцээрт талууд ямар үүрэгтэй оролцох, тэдний хувь, хандив ямар байх тухай олон нийтэд тодорхой мэдээлээгүй бөгөөд үнэндээ бол албан ёсоор хараахан тодорхойлоогүй байна. Улаанбаатар төмөр замын дагуу зэрэгцүүлэн тавьж магадгүй байгаа тэрхүү хий дамжуулах хоолойг ашиглах нь Монгол улсад ихээхэн ач тустай байх болно. Барилга байгуулалтын бусад томхон төслүүдийн нэгэн адил дамжуулах хоолой тавих дээрх ажлыг хэрэгжүүлж уг хоолойг ашиглах нь ажлын орон тоо бий болгох, хүмүүсийн ур чадварыг дээшлүүлэх өргөн бололцоо бүрдүүлэх болно. Энэ хоолойг ажиллуулснаар дамжуулан өнгөрүүлсний төлбөр, ашгийн ногдол гэх мэт хэлбэрээр ашиг тус илрэх юм. Мөн

Монгол улс өөрөө ялангуяа Улаанбаатар хот болон хий дамжуулах хоолойн ойролцоох хот суурин газарт зориулан шатдаг хий импортоор авч ч болно. Хий дамжуулах хоолойг аж үйлдвэржсэн бусад төвүүдэд салаалан тавьж болох юм. Гэхдээ мэдээж энэ нь санхүүжүүлэлтийн хувьд нэлээд бэрхшээлтэй байх биз ээ²⁴.

Хүнсний үйлдвэрлэл: Өнгөрсөн 20 жилийн дотор уул уурхайн салбар түргэн хурдацтай хөгжиж, Монгол улс хотжисны нөлөөгөөр нийтлэг хэрэглэгдэж байсан хоол хүнсний бүтэц найрлага өөрчлөгджээ. Малын гаралтай гол хоол хүнсний оронд хот суурин газрынхан газар тариалангийн гаралтай хоол, хүнс, тухайлбал хүнсний ногоог шууд, харин цагаан идээг шууд бус замаар хэрэглэж байна.

Гэвч тус улс малын гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг уламжлалт худалдааныхаа хавсарга болгож, импортыг орлох газар тариалангийн салбарыг хөгжүүлэх арга зам сонгож авчээ.

Тус салбарын үр ашгийг дээшлүүлэх гэж олон жил бүтэл муутайхан оролдсон боловч Азийн хөгжлийн банк энэхүү чиг бодлогыг өөрчлөхүйц хөдөө аж ахуйн программын төслийг боловсруулж байна²⁵. Уг төслийн утга агуулгыг одоогоор нийтэд хараахан танилцуулаагүй байна.

Дэлхийн бусад улс орноос технологи авч хэрэглэвэл нүүдлийн мал аж ахуйн харьцангуй давуу талыг ч, газар тариалан, түүнтэй холбоотой бусад арга ажиллагааны харьцангуй давуу бус талыг ч сайжруулж болох юм. Шатдаг хий, нүүрс олборлолтын салбартай харьцуулбал хөдөө аж ахуйн технологи олж авахад техникийн тусламж, гадаадын хөрөнгө оруулалт харьцангуй бага, магадгүй тээврийн салбарын хөгжил сул дорой байгаа зэргээс болоод ихээхэн хүндрэл бэрхшээл тулгарч байна. Ингэхлээр ЗХА-ийн бүс нутгийн хамтын ажиллагааны төслүүдэд оролцох боломжийн хувьд ч хязгаарлагдмал. Ер нь Монголынхтой харьцангуй адил төстэй нөхцөл дэх бэрхшээлийг үр дүнтэй гэтлэн давж чадаж байгаа дэлхийн тийм л улс орноос ажил төрлийн ашиг тустай арга туршлага олдох илүү магадлалтай.

Уламжлалт мал аж ахуйн онцгой чухал нэг асуудал нь техникийн шинэчлэлтийн явцад мал аж ахуйн салбарын өвөрмөц хөдөлгөөнт байдлыг хэвээр байлгах явдал бололтой. Үүнд малчдын моторт техникийн хангамжийг улам сайжруулах, ялангуяа хоол ундаа хийх, гэрэл цахилгаан, дулаалгадаа нарны эрчим хүч ашиглах бололцоог нэмэгдүүлэх зэрэг сайн талууд бас ч байх ёстой. Түүнчлэн сүргийн бүтцийг сайжруулан хамгаалах мал эмнэлгийн үйлчилгээ мал нядалгааны газар, мах хөргүүр, арьс шир гэх мэт малын гаралтай түүхий эдэд хийх анхан шатны боловсруулалт, бүтээгдэхүүнийг төвлөрсөн газруудад хүргэх тээврийн хэрэгсэл гэх мэт хэд хэдэн нэмэлт арга хэмжээ шаардлагатай. Энэ бүх чиглэлд өөрчлөлт хийхэд гадаадын техникийн тусламж, авто замыг сайжруулахад зориулсан зээл, буцалтгүй тусламжаас эхлүүлээд

бүх нөөц бололцоог ашиглаж байна. Монгол улс Англиас нүүдлийн нядалгааны машин авчээ²⁶. Гадаадын бага хэмжээний шууд хөрөнгө оруулалтаар хувцас, махны үйлдвэрлэлийг (хиам хийх) сайжруулж байна²⁷. Ингэснээр Орост мах экспортлож²⁸, мөн Зүүн Азийн хаа нэгтээ нохой, адуу, сарлагийн махыг улам их сонирхож байна. Харин ноолуур, малын гаралтай бусад түүхий эд боловсруулах талаар мэдэгдэхүйц ахиц гараагүй байна.

Гадаадын хөрөнгө оруулалт, техникийн тусламж үр тариа, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, малын тэжээлийн аж ахуй зэрэгт илүү зонхилж байгаа нь тэдгээрийг хотын хүн амын хүнсний хангамжид онцгой чухал хэмээн үзэж байгаатай холбоотой болов уу. Зөвлөлтийн дэмжлэг, загвараар байгуулсан улсын 55 фермийг 1991 онд АХБ-ны тусламжтайгаар хувийн (хоршоолсон) 300 ферм болгож шинэчлэн зохион байгуулсан билээ²⁹. Газар тариалан, үр тариа, төмс хүнсний ногооны үйлдвэрлэл ихээхэн буурсан нь урьд өмнө Оросоос авдаг байсан үр, бордоо, шатахуун, сэлбэг хэрэгсэл гэх мэт бүх зүйл хомсдсоноос болсон байна³⁰. Үүний сацуу арилжааны банкууд зээл өгөхөөс татгалзаж, зээлийн хомсдол бий болгосныг дурдах хэрэгтэй.

Энэ мэт бэрхшээлийг арилгахын тулд бордооны³¹ хэрэгцээг импортоор хангахад чармайлт тавьж, сүү боловсруулах³², үр тариа хадгалах зэрэг хөдөө аж ахуйн технологийг³³ сайжруулах, адууны махны ферм байгуулах³⁴, шинэ комбайн худалдан³⁵ авахад Япон улс буцалтгүй тусламж, хөнгөлттэй зээл олгосон байна. Монгол улс Чехээс чихрийн манжингийн үйлдвэр оруулж ирсэн боловч засгийн газрын зүгээс санхүүгийн бэрхшээлтэй байснаас энэ ажил бүрэн гүйцэд хэрэгжсэнгүй. Хүнсний үйлдвэрлэлд зарим хөрөнгө оруулалт хийсний дотор Чехийн Эшиан инвестмент капитал Групп пүүстэй талх-нарийн боовны хамтарсан үйлдвэр байгуулжээ³⁷.

Энэ бүх хөрөнгө оруулалтын олонхи нь одоогоор үр өгөөж муутай байна. Үр тарианы үйлдвэрлэл дорвитой нэмэгдээгүй, ургацын хэмжээ нийтдээ багасч эхэлмэгц Монгол улс урьдын татаас дэмжлэг туслалцаа гэж байхгүй болсон үед алдагдалд орохгүйн эрхээр цаг агаарын нөхцөлдөө илүү тохиромжтойг нь бодолцон төмс, хүнсний ногоо тариалах аргад шилжсэн байна³⁸. Гэвч байдал нийтдээ тааруухан байгаа учраас цаашдаа фермийн зохион байгуулалтыг, дэлхийн аль ч улс оронд харьцангуй үр нөлөөтэйгээ харуулсан гэр бүлийн фермийн аж ахуй байгуулах чиглэлээр өөрчлөх шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

Олон улсын хэмжээнд, ялангуяа Зүүн хойт Азийн улсуудтай эдийн засгийн талаар хамтран ажиллах нь Монгол улсад хэд хэдэн талаар ашигтай юм. Юуны өмнө, Азийн хөгжлийн банк, Олон улсын валютын

сан, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагууд төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих үед эдийн засгийг нь тогтвортой байлгахад Монгол улсад техникийн тусламж, санхүүгийн дэмжлэг үзүүлээ. Ийм хамтын ажиллагааны үр дүн үнэхээр бодитой байлаа. Орос болон ЭЗХТЗ-ийн гишүүн байсан бусад улсынхтай харьцуулахад Монгол улсын шилжилтийн үеийн саад бэрхшээл арай аядуу зөөлөн байлаа³⁹.

Монгол улс шилжилтийн цаашдын үйл явцдаа олон улсын санхүүгийн дээрх байгууллагуудаас гадна Япон улсаас зээлийн тусламж авахыг сонирхож байна.

Япон улсаас (мөн бусад улс орноос) үзүүлж байгаа буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн дийлэнхи нь монголын дэд бүтцийг сайжруулах, урьд өмнө барьж байгуулсан нүсэр том уурхай, фермийг шинэчлэх хөрөнгө оруулалтад зориулагдсан юм. Харин арилжааны хөрөнгө оруулалтын ихэнх нь жижиг, дунд үйлдвэр, боловсруулах үйлдвэрт зориулагдаж байна. Гэвч уул уурхайн хууль тогтоомжид өөрчлөлт орж, улсын үйлдвэрүүдийг хувьчлах ажил эрчимжсэнээр гадаадынхан арилжааны хөрөнгө оруулалт хийх, уул уурхайн олборлох чиглэлийн үйл ажиллагаанд оролцохыг сонирхож болжээ.

Хятад улс ерөнхийдөө худалдааг дэмжих сонирхлын үүднээс Монголтой хамтран ажиллахдаа тээврийн салбарын хөгжилд голлон анхаарч байна. Хятад улс Тяньжин боомт хүртэл дамжин өнгөрөх бололцоог Монгол улсад олгож, Орос, Умард Солонгостой хамтарсан Түмэн голын төсөлд оролцох бололцоо олгохыг санал болгож байгаа ажээ. Монголын зүүн нутгаас хятадын Зилинь мужаар дамжин Түмэн голын бүсэд хүрэх зам, хэрэв экспортын (импортын) зөвшөөрөлтэй байвал бусад аль ч зам, боомтоос илүү ашигтай байх болно. Хятад улс монголын нефтийг экспортоор авахыг хүсч байгаа боловч монголын зүүн нутаг дахь экспортын нэмэлт бүтээгдэхүүн болох нүүрсийг авах эсэх нь тодорхойгүй байна. Монголын нутгаар дайруулан шатдаг хий дамжуулах хоолой тавихыг Хятадаас гадна Орос, Япон, Өмнөд Солонгос бас сонирхож байгаа бөгөөд бүх тал тус хоолойг боломжийн зардал төсвөөр барьж байгуулснаар ашиг олж чадна гэсэн байр суурьтай байна. Зүүн хойт Азийн эрчим хүчний сүлжээг хөгжүүлэх саналын тухайд ч мөн ингэж хэлж болох бөгөөд энэ хамтын ажиллагаанд Монгол улс нүүрсний баялаг нөөцөөрөө оролцож болох юм.

Франц, Голланд улс болон НҮБ-ын Хөгжлийн программаас Монголд үзүүлж буй албан ёсны тусламж нь байгаль орчны бохирдолтоос сэрэмжлэх, хяналт тавихад зориулагдаж байна⁴⁰. Байгаль, орчны бохирдолт Монголын аж үйлдвэржсэн хот суурин газар төдийгүй хөдөө хязгаар нутагт ч анхаарах асуудал болж байна.

References and Notes

1. Asian Development Bank. *Asian Development Outlook, 1997 and 1998*, p. 229 (Table A.7).
2. *Ibid.*, p. 230 (Table A.8).
3. *IMF Staff Country Report*, No. 97/92 (October 1997), p. 73 (Table 42).
4. *Ibid.*, p. 74 (Table 43).
5. Economist Intelligence Unit. *Country Profile: China/Mongolia, 1997/1998*, p. 83.
6. *IMF Staff Country Report*, No. 97/92, p. 74 (Table 43).
7. *Ibid.*, No. 96/24 (March 1996), p. 2.
8. *Far Eastern Economic Review* (19 January 1998) (Economic Monitor).
9. Economist Intelligence Unit. *Country Report: China/Mongolia, I/1998*, p. 48.
10. *Ibid.*
11. *Ibid.*, I/1996, p. 42.
12. *Ibid.*, I/1998, p. 48.
13. EIU. *Country Profile: China/Mongolia, 1997/1998*, p. 79.
14. EIU. *Country Report: China/Mongolia, I/1997*, p. 55; ii/1997, pp. 52, 56.
15. *IMF Staff Country Report*, No. 97/92, p. 37.
16. *Ibid.*, pp. 38, 39.
17. *World Bank Discussion Papers*, No. 145 (January 1992), p. 21.
18. EIU. *Country Profile: China/Mongolia, 1997/1998*, p. 77.
19. EIU. *Country Report: China/Mongolia, III/1997*, pp. 48-49.
20. *Ibid.*, I/1998, pp. 50-51 plus note 13.
21. FEER, 30 October 1997, p. 31.

22. *Ibid.*, 26 February 1998, p. 48.
23. EIU. *Country Report: China/Mongolia*, I/1998, p. 48.
24. The total length of the pipeline has been projected as 3,600 km and the cost of its construction as \$7 billion (FEER, 26 February 1998, p. 48). Other sources have mentioned even larger amounts. A summary of the Sino-Russian Joint Statement on Relations appears in *Beijing Review*, 22-28 December 1997, pp. 7-13.
25. EIU. *Country Profile: China/Mongolia*, 1997/1998, p. 80.
26. EIU. *Country Report: China/Mongolia*, IV/1997, pp. 43-44.
27. EIU. *Country Profile: China/Mongolia*, 1997/1998, p. 83.
28. EIU. *Country Report: China/Mongolia*, IV/1997, p. 46.
29. EIU. *Country Profile: China/Mongolia*, 1997/1998, p. 84.
30. EIU. *Country Report: China/Mongolia*, II/1997, p. 57.
31. *Ibid.*, p. 55.
32. *Ibid.*, p. 52.
33. *Ibid.*, p. 59.
34. *Ibid.*, p. 57.
35. *Ibid.*, IV/1997, p. 43.
36. *Ibid.*, II/1997, p. 57.
37. *Ibid.*, III/1997, p. 46.
38. *Ibid.*, p. 45.
39. Asian Development Bank, *Asian Development Outlook*, 1997 and 1998, pp. 223 ff.
40. EIU. *Country Report: China/Mongolia*, I/1997, p. 59, II/1997, p. 52.
41. *Ibid.*, II/1995, p. 45.